Баянхонгор аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

БШУГ-ын даргын 2018.04.03-ний өдрийн 91 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “БШУГ-ын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,020,399.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 18,569.0 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	174,507.2	177,766.8	3,259.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	27,674.6	1,478.8	(26,195.8)
Урьдчилгаа	1.6	1.6	-
Бараа материал	146,831.0	176,286.5	29,455.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	827,233.4	842,872.7	15,639.3
Үндсэн хөрөнгө	1,000,832.0	1,050,154.1	49,322.1
Хуримтлагдсан элэгдэл	(173,598.7)	(207,281.4)	(33,682.8)
Нийт хөрөнгө	1,001,740.6	1,020,639.6	18,899.0
Өр төлбөр	760.9	1.6	(759.4)

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,000,979.7	1,020,638.0	19,658.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,001,740.6	1,020,639.6	18,899.0

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 27,674.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 26,195.8 мянган төгрөгийн авлага барагдуулж оны эцэст 1,478.8 мянган төгрөгийн авлага нь хувь хүмүүсээс авах авлага 600,0 мянган төгрөг, НДШ-ийн авлага 129,0 төгрөг, ҮЭ-ийн авлага 131,9 төгрөг, байгууллагаас авах авлага 377,8 мянган төгрөг байна. Энэ нь 2022 онд үүссэн авлага тул 2023 оны 1-р улиралд багтааж барагдуулах тайлбарыг шалгагдагч байгууллагаас өгсөн тул зөвлөмж өгөв.

Бараа материалын дансны үлдэгдэл 176,286.5 мянган төгрөг болж өмнөх оноос 29,455.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,920.8 мянга төгрөгийн аж ахуйн материал, БЕГ-аас бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 24,534.6 мянган төгрөгийн сурах бичгийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,050,154.1 мянган төгрөг болж 49,322.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5,050.0 мянга төгрөгийн хөрөнгө, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 39,422.1 төгрөгийн тоног төхөөрөмж, НҮБ-ийн хүүхдийн сангийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр зөөврийн компьютер 4,850.0 мянган төгрөгийн хөрөнгийг дансанд нэмэгдсэн байна.

Тайлант онд өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,020,398.1 мянган төгрөг болж 19,419.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 19,418.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,592,629.9 мянга, нийт зарлагыг 3,592,629.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал 3,577,801.2 мянган төгрөгөөр, 2,984,106.9 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 3,592,629.9 мянган төгрөг болгож 608,523.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801,71802,71808 хөтөлбөрийн 80101, 80802, 80226, 80219 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,592,959.9 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,592,629.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй 88,019.0 мянган төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,504,610,8 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 88,019.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71808 Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага	609,250.5	605,153.3	4,097.2	99,3
2	80101 үндсэн үйл ажиллагааны зардал	473,606.8	470,786.9	2,819.9	99,4
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	122,663.2	121,385.8	1,277.3	98,9
4	80219 Харуул хамгаалалтын зардал	3,492.6	3,492.6	0	0
5	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	9,487.9	9,487.9	0	0
6	71801 Сургуулийн өмнөх боловсрол	640,613.5	608,380.7	32,232.8	94,9
7	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	640,613.5	608,380.7	32,232.8	0
8	71802 Ерөнхий боловсрол	2,342,765.9	2,291,076.9	51,689.0	97,7
9	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,342,765.9	2,291,076.9	51,689.0	
	Нийт дүн	3,592,629.9	3,504,610.9	88,019.0	97,6

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030015401 тоот дансанд 209,348.2 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

		/төгрөгөөр/
д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	НҮБ-ийн хүүхдийн сангийн төсөл хөтөлбөрийн санхүүжилт	283,469.6
2	2021 оны жилийн эцэст нэмэлт дансны татан төвлөрүүлэлт улсын төсвөөс өглөгөөр тусгасан мөнгө орж ирсэн	27,238.0
3	Аймгийн Засаг даргын Захирамж А/183 сургалтын арга хэмжээний зардал	9,985.0
4	Аймгийн Засаг даргын Захирамж А/... Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3-ыг хэрэгжүүлэх зардал 7.1.13	5,000.0
5	Боловсролын ЧШ төсөл-ҮАЗ/ сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, няналт-шинжилгээ хийх зардал	1,922.0
6	БШУЯам хөтөлбөр арга хэмжээ А/124 дүгээр тушаалаар сургалтын зардал	600.0
7	Корунд ГЕО ХХК сургалтын төлбөр	200,000.0
8	Боловсролын Ерөнхий газар А/106, А/148, А/192, А/353, А/342, тоотоор сургалтын зардал	48,062.5
9	Аймгийн Засаг даргын Захирамж А/307 мөнгөн урамшуулал	6,510.0
10	Аймгийн ИТХ захирамж 75 мөнгөн урамшуулал	5,610.0
11	Боловсролын үнэлгээний төв А/88 тушаал бичиг хэргийн зардал	3,622.5
12	Аймгийн Засаг даргын Захирамж А/638 зөвлөгөөнд оролцогчдод дэмжлэг	2,480.0
13	Аймгийн Засаг даргын захирамж А/342 сургуулийн сэтгэл зүйч бэлтгэх зардал	2,000.0
	НИЙТ ДҮН	596,499.6

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор аймагт нэн шаардлагатай мэргэжлээр сурч байгаа оюутны сургалтын төлбөрт дэмжлэг болгож Корунд Гео ХХК-аас 200,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын тамгын газрын гаргаж өгсөн жагсаалтын дагуу сургууль оюутны данс руу шилжүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

№	Хөтөл бөр	Эдийн засгийн ангилал	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
2 1 0 1	71808-80101, 80219, 80802	210101-210104	2022.01.01-2022.12.31	Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу Төрийн захиргааны 15 алба хаагч, төрийн үйлчилгээний 9 алба хаагч, нийт 24 алба хаагчийн 1-12 дугаар сарын цалинг бодож олгосон.	99,4%	323,470,600	321,619,085
		210201-210205	2022.01.01-2022.12.31	Алба хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ тайланг сар бүр төлж, өр авлагагүй ажилласан.	99,9%	40,485,400	40,484,820
		210301	2022.01.01-2022.12.31	Боловсролын газар нь цахилгааны зардлыг тоолуурын заалтын дагуу төлж барагдуулсан.	99,9%	3,016,500	3,015,640
		210302	2022.01.01-2022.12.31	ФЮМ ХХК-тай 2022 оны 4-р сараас эхлэн халаалтын гэрээний дагуу түлш халаалтын зардлыг шилжүүлсэн.	89,9%	36,718,900	33,042,979
		210303	2022.01.01-2022.12.31	Чандмань-Баянхонгор ХК-ай байгуулсан гэрээний дагуу төлбөрийг 100 хувь шилжүүлсэн.	43,4%	704,200	1,619,850
		210304	2022.01.01-2022.12.31	RMB ХХК-тай Голомт банкны 5-р давхарт 6 өрөөг түрээслэн үйл ажиллагааг 2022 оны 3-р сар хүртэн байралсан түрээсийн төлбөр шилжүүлсэн	68,6	5,106,200	7,440,000
		210401	2022.01.01-2022.12.31	Боловсролын газар нь ЕБС.СӨБ-ийн багш нарын сургалтын бичиг хэрэг, алба хаагчдыг бичиг хэргийн материалаар хангаж, зардлыг 100 хувь шилжүүлсэн.	100%	3,016,500	3,015,640
		210402	2022.01.01-2022.12.31	ЕБ-ийн 33 сургууль, СӨБ-ийн 43 цэцэрлэгт сургалт, арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах ажилаар хангах хүрээнд тээврийн хэрэгслүүдэд үйлчилгээ хийж, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангасан.	100%	2,000,300	2,000,300
		210403	2022.01.01-2022.12.31	Тус газар нь 70442115, 70443643 суурин утасны төлбөрийг Монголын цахилгаан холбоотой гэрээ хийж, 100 хувь төлж барагдуулан холбоо зарлан мэдээллийн бэлтгэл бэлэн байдлыг хангасан.	89,4%	416,200	372,300
210404	2022.01.01-2022.12.31	Өнөөгийн Баянхонгор сонин цахилга, бусад ном хэллэл захиалга хийсэн	100%	154,700	154,400		

**Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210405	2022.01.01- 2022.12.31	Цэвэр хот ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу хог хаягдлын зардлыг 100 хувь төлж, Номгон Ариусал ХХК-тай гэрээ хийж хортон мэрэгчдийн устгал ариутгал хийлгэж 100% барагдуулсан.	100%	1,349,700	1,349,700
210406	2022.01.01- 2022.12.31	Байгууллагын цэвэрлэгээний бодис алба хаагчдын цэвэр тохитой орчинд ажиллах, ээлжийн алба хаагчид үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоо хангагдсан.	100%	1,838,600	1,883,600
210604	2022.01.01- 2022.12.31	Боловсролын газар нь 2022 оны 3-р сард Номгон сургуулийн 2-р байранд урсгал засвар хийж 1,2-р давхарын кордор, 8 өрөөний хан тааз шалыг бүрэн будаж, цонхны шил, зарим нэг паарыг солиж. Нойлын өрөөний суултуур хүүхдийн зориулалтын байсанг бүрэн солиж, гадна худгаас орсон нойлын шугамыг солиж, гадна хайш хийсэн засварын ажлыг Болд Суврага ХХК, Дэлгэрэх Асгат ХХК-тай гэрээ хийж гүйцэтгүүлсэн	100%	32,870,000	32,870,000
210801	2022.01.01- 2022.12.31	Архивийн нөхөн бүрдүүлэлтын бичиг хэрэгийн зардал, программ хангамжийн үйлчилгээний төлбөр төлсөн	100%	295,500	295,000
210802	2022.01.01- 2022.12.31	Аудит, Баталгаажуулалтын төлбөр төлсөн	100%	250,000	250,000
210803	2022.01.01- 2022.12.31	Жолоочийн хариуцлагын төлбөр, автомашины даатгалын төлбөр төлсөн	100%	450,000	450,000
210804	2022.01.01- 2022.12.31	Тус газар нь 2 автомашинтай тээврийн хэрэгсэлийн татварын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалаас төлсөн		385,000	
210805	2022.01.01- 2022.12.31	Тус газар нь 2 автомашинтай тээврийн хэрэгсэлийн татварын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалаас төлсөн		80,000	
210806	2022.01.01- 2022.12.31	Мэдээлэл технологийн үйлчилгээ, программ хангамжийн үйлчилгээний төлбөр төлсөн	100%	369,000	369,000
210901	2022.01.01- 2022.12.31	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-тай гэрээ хийж суваг ашиглалтын төлбөрийг 100% хийж барагдуулсан, Сургалтын үйл ажиллагаан шаардлагтай бичиг хэрэг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн төлсөн	100%	9,293,300	9,293,060
210902	2022.01.01- 2022.12.31	ЕБ-ийн 33 сургууль, СӨБ-ийн 43 цэцэрлэгт сургалт, арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах ажил, шалгалт мониторинг хийхэд хангах хүрээнд тээврийн хэрэгслүүдэд шатахууны төлбөр, сургалтын цай хоолны төлбөр, бичиг хэрэг	100%	13,419,300	13,419,300

**Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

			хулдаасан хэвлэлийн зардалыг гаргаж төлбөр тооцоог хийж ирлээ			
80219-210801	2022.01.01-2022.12.31		Боловсролын газар нь аж ахуйн хашаа агуулах гэр хороололд 5-4-16 тоотод байралдаг сар бүрийн харуулын төлбөрийг үйлчилгээний ажилтан П.Сэржмаад давахр хариуцуулан харуулын хөлсыг олгодог байгаа.	100%	3,492,600	3,492,600
80226-210801	2022.01.01-2022.12.31		Хичээлийн 2-р байрны урсгал засварын ажлын тал хувийг Болд Суврага ХХК-д төлөж, мөн суваг ашиглалтын гэрээгий төлбөрийг төслөн	100%	9,487,900	9,487,900
213204	2022.01.01-2022.12.31		Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн ажлын байранд ажилла хийж байгаад насан өөд болсон. Төрөөс олгох 60 сартай тэнцэх мөнгөн тэтгэмжийг БШУЯамнд санал хүргүүлж төсөвт нэмэлт тоотгол хийж олгосон	100%	47,494,200	47,494,200
213207	2022.01.01-2022.12.31		2022 онд өндөр настаны тэтгэмж авч гарсан 3 ажилтанд 36 сартай тэнцэх мөнгөн тэтгэмжийг бүрэн олгосон	98,3%	74,605,000	73,327,613
213209	2022.01.01-2022.12.31		Байгууллагын ар гэрийн гачигдал, хүүхдийн баярын үйл ажиллагаан нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал олгосон	100%	564,000	564,000

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга Ж.Алтанцэцэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Оюунтуяа нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 4,385,428.1 мянган төгрөгөөс 43,854.3 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 30,698.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 3,592,629.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 100 мэдээллийг хугацаанд нь, 50 мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн бол 1 мэдээллийн сайтад байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	4	1
2	Хагас жил	4	4	0	4	0
3	Улирал бүр	1	4	2	2	0
4	Сар бүр	3	36	27	9	0
5	Тухай бүр	8	96	65	31	0
6	Нийт	27	151	100	50	1

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 7,184,901.3 мянган төгрөгийн, зарлагын мөнгөн гүйлгээ 4,260,401.3 мянган төгрөгийн нийт 83 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой төгрөгийн 15 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Дээрх байдлаас үзэхэд орлого зарлагын мөнгөн гүйлгээг 11, 12 дугаар сард өссөн дүнгээр мэдээлж давхардуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 424,8546.4 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 220,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 204,856.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2022.05.22-ны өдрийн 511 дугаар албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	220,000.0	1	220,000.0	100
Зөвлөмж	3	204,856.4	3	204,856.4	100
Нийт дүн	4	424,856.4	4	424,856.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 993,968.5 мянган төгрөг болон Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 1,978,816.7 мянган төгрөгийн зарцуулалтыг анхан шатны баримттай нэг бүрчлэн тулгах нь цаг хугацааны хувьд боломжгүй байсан тул тусгайлан гүйцэтгэл, нийцлийн аудитаар авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 271,197.9 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд албан шаардлага өгч, өр авлага, төсөл, хөтөлбөрт бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 3 зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. КОРУНД ГЕО ХХК-ний ямар шалгуур үзүүлэлтээр олгох эсэх нь тодорхойгүй 200.0 сая төгрөгийн оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2. “бүх шатны боловсролын үйлчилгээ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-г заасан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хувийн компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж байгаа оюутны тэтгэлэг олгох ажлыг Төрийн сангийн дансаар дамжуулж байгааг зогсоож, тухайн компанид өөрөө энэ арга хэмжээгээ хэрэгжүүлэх талаар мэдэгдэх, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

1. Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн зардлын 69,957.6 мянган төгрөгийн 12 гүйлгээг Е-баримтгүй хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгчээс Е баримтгүй хийсэн гүйлгээнд баримтыг нөхөн бүрдүүлж 69,957.6 мянган төгрөгийн 10 хувьд ногдох 6,957.6 мянган төгрөгийг төсөвт төлүүлэх албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

1. НҮБ-аас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн төсвийн тооцоолол хийхдээ нэгж норм норматив баримталдаггүй, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, зах зээл дээрх үнийн судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.7-д заасан “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хөтөлбөрт бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

2. Тайлант оны эцсийн байдлаар 1,238.8 мянган төгрөгийн авлагатай, 1.5 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгчтэй хийх гэрээг цаг тухай д тооцоо нийлж, өр авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөв.

2. Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй, мөн нийт 151 мэдээ мэдээлэхээс 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т заасан “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т заасан Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад хуульд заасан мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх албан шаардлага биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-оОо-

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
КОРУНД ГЕО ХХК-ний ямар шалгуур үзүүлэлтээр олгох эсэх нь тодорхойгүй 200.0 сая төгрөгийн оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.	1	200,000.0			1	200,000.0		
Бэлтгэн нийлүүлэгчид 69,957.6 мянган төгрөгийн 12 гүйлгээ Е баримтгүй хийсэн байна.	1	69,957.6			1	69,957.6		
Тайлант оны эцсийн байдлаар 1,238.8 мянган төгрөгийн авлагатай, 1.5 мянган төгрөгийн өглөгтэй байна.	1	1,240.3					1	1,240.3

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ДҮН	2	271,197.9			2	269,957.6	1	1,240.3
-----	---	-----------	--	--	---	-----------	---	---------

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй, мөн нийт 151 мэдээ мэдээлэхээс 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0					1	0
Дүн	1		0	0	0	0	1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
НҮБ-аас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн төсвийн тооцоолол хийхдээ тогтсон норм норматив баримталдаггүй, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, зах зээл дээрх үнийн судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй байна.	1	0	0	0	0	0	1	0
Нийт дүн	2	0	0	0	0	0	0	0

-оОо-